

## “НЭГ БҮС НЭГ ЗАМ”, МОНГОЛЫН “ТАЛЫН ЗАМ” ТӨСЛИЙГ УЯЛДУУЛАХ НЬ

*Жан Сюйжие<sup>1</sup>*

**Товч агуулга:** “Нэг бүс нэг зам” стратегийн чухал хэсэг болох “Хятад, Монгол, Орос гурван улсын эдийн засгийн коридор” батлагдсан ба энэхүү бүс нутгийн хамтын ажиллагааны хүрээнд Монголын “Талын зам” стратеги уялдан холбогдох юм. Хятадын “Нэг бүс нэг зам”-ыг Монголын “Талын зам” стратегитай холбох явдал цаг үеийн ч шаардлага, ашиг сонирхлын ч давхцал билээ. “Нэг бүс нэг зам”-ын бүтээн байгуулалтын хэтийн зорилт бол “таван зүйлийн хэлхээ холбоо”-г бий болгох, тэр дундаа “замыг замтай” түргэн шуурхай холбох явдал юм. Дэд бүтэц, худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааг голчилсон энэ ухагдахуун бол чухамдаа “таван зүйлийн хэлхээ холбоо”-г бий болгох хамтдаа хожсон хамтын ажиллагаа билээ.

**Түлхүүр үг:** Нэг бүс нэг зам, Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор, Талын зам, “Таван зүйлийн хэлхээ холбоо”

Эдийн засгийн даяаршил гүнзгийрч, бүс нутгийн эдийн засгийн интеграци түргэсч, Хятадын гадаад орчин хурцдаж, эдийн засгийн өсөлтийн удааширал улам дарамт болж буй ийм цаг үед Хятад улс эдийн засгийн бүтцийн өөрчлөлт явуулж, шилжилтээ шат ахиулах, эдийн засгийн хөгжлийн шинэ үе шат руу алхан орж байна. Гадаад дотоодын хурцадмал нөхцөл байдлын эсрэг 2013 онд Ши Жиньпин

дарга “Торгоны замын эдийн засгийн бүс” ба “XXI зууны далайн торгоны зам” хэмээх стратегийн үзэл санааг дэвшүүлсэн. “Нэг бүс нэг зам” бол Хятадын өөрчлөлт шинэчлэлтийг гүнзгийрүүлэх чухал цэг бөгөөд Евразийн эх газрын улс орнуудад, тэр бүү хэл дэлхий дахинд ч хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэх нэг боломж билээ. Тэр тусмаа эдийн засгийн хөгжлийн “шинэ хэвийн байдал”-тай (New normal) тулгараад буй цаг үед гадаадад нээлттэй байхад чиглэсэн зохицуулалтыг байнга хийж буй нь хятадын эдийн засгийн хөгжлийн хурд саарсан энэхүү нөхцөл байдалд авч хэрэгжүүлсэн идэвхтэй шийдвэр байлаа. Энэхүү стратегийн үзэл санааг чиг болгон Хятад улс эдийн засгийн коридор, эдийн засгийн бүс байгуулах шат дараатай санаачилга дэвшүүлэн зүтгүүлсний нэг нь Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор билээ.

“Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор”-ыг Ши Жиньпин дарга 2014 оны 9 дүгээр сард болсон Хятад, Монгол, Оросын төрийн тэргүүн нарын уулзалтын үеэр дэвшүүлсэн юм. Гол агуулга нь Оросын Евразийн төмөр зам, Монголын “Талын зам”-ыг угтуулан холбож, зам харилцаа, бараа тээвэр, улс дамнасан цахилгаан сүлжээг үүсгэн, гурван улсын эдийн засгийн хамтын ажиллагааны коридорыг бий болгоход оршиж буй. Энэ үндсэн дээр 2015 оны 7 дугаар сард Хятад, Монгол, Орос гурван улсын удирдагчид “БНХАУ, ОХУ, Монгол Улс гурван талт хамтын ажиллагааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийг баталж, “Гурван улсын уламжлалт, найрсаг, харилцан ашигтай харилцааг тус тусынхаа гадаад бодлогын стратегийн нэг чиглэл болгох, харилцан хүндэтгэсэн, адил тэгш туслалцсан, сайн хөршийн найрсаг, дотоод хэрэгт үл оролцох зарчимд тулгуурласан бүх талын хамтын ажиллагаагаа өргөтгөх хүсэлтэй” байгаагаа зарласан юм. 2016 оны 6 дугаар сард, Хятад, Монгол, Оросын төрийн тэргүүн нар “Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-г гарын үсэг зурав. “Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор” бол “Нэг бүс нэг зам” үзэл баримтлалын өргөжүүлсэн нэмэлт хэлбэр бөгөөд “Нэг бүс нэг зам” стратегитай нэгэн цогц болно. Мөн Ази, Европын эх газраар Хятад, Төв Азийн хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай анхны санаа нь тэлсээр Зүүн хойд чиглэлд Хятад улс Орос, Монголтой хамтран ажиллах тухай агуулгатай болсон билээ. Өөрөөр хэлбэл “Нэг

<sup>1</sup> Жан Сюйжие: /Хятад/, Хармөрөн мужийн ШУА-ийн Зүүн хойд Азийн хүрээлэн, ЭША Ван Пөн: /Хятад/, МУИС-ийн Олон улсын харилцаа нийтийн удирдлагын сургуулийн Олон улсын харилцааны магистр

бүс нэг зам”-ын зорилт төсөөллөөс бодит руу биежиж, Монголын “Талын зам” стратегитай холбогдох боломжтой болсон ажгуу.

Хятадын “Нэг бүс нэг зам” Монголын “Талын зам”-тай холбогдох нь эрин цагийн шаардлага билээ, ойлголт, агуулга, ашиг сонирхол давхцаж буй нь стратегиуд уялдан холбогдох бүрэн боломжтойг илтгэнэ.

Эн тэргүүнд ойлголтын зөрүүгүй, харин ч өндөр түвшинд давхцаж буй билээ. “Талын торгоны зам” хэмээх ойлголт түүхэнд бий. Хятадын хойд хэсгийн тал нутаг, Монголын уудам тал болон Еврази хоорондох тал хээрийн бүс нутгаас бүрддэг. Хятад ч, Монгол ч цөм энхүү “Талын торгоны зам”-ын түүхэн үнэ цэнийг хүлээн зөвшөөрдөг бөгөөд өнөөгийн “Нэг бүс нэг зам”-ын маршрутад өөрийн гэсэн онцлог давуу талтай хэвээр байх төдийгүй дахин тодрон зурайж, ирээдүйд илүү их үүрэг гүйцэтгэн, Хятад, Монголын эдийн засгийн харилцаа, соёлын хэлхээ холбоонд чухал хувь нэмэр оруулахаар байгаа нь талууд “Талын торгоны зам”-ын хөгжсөн түүх хийгээд ойлголтыг чухалчлан үзэж буйгаар илэрч байна.<sup>1</sup> Эдийн засгийн бодит байдлаас харахад шинээр сэргэж буй эдийн засгуудын нөөц баялгийн эрэлт хэрэгцээ буурч, олон улсад гол бүтээгдэхүүний үнэ бууж буй хүчин зүйлийн нөлөөгөөр Монголын эдийн засгийн өсөлт унасан билээ. Эрдэс баялгийг экспортлогч орны хувьд эдийн засгийн хөгжил нь хүндрэлтэй тулгарсан нөхцөл байдалд Монгол Улс газарзүйн байршлын давуу талаа ашиглан, Хятад, Орос хоёр их гүрэн, том зах зээлийн дунд оршдог давуу талаа илүүтэй хөхиүлэн, худалдаа тээврээр эдийн засгаа цэцэглүүлэхээр найдаж буй. Монголын тал “Торгоны замын эдийн засгийн бүс” санаачилгын хүрээнд “Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк”(АДБХОБ)-ыг дэмжих, хамтран ажиллах үүсгэн санаачлагч орнуудад идэвхтэй оролцох цагийн тохироо нэгэнт бүрэлдсэн гэдгээ илэрхийлсэн билээ.<sup>2</sup> Хятад улс Монгол Улсын хамгийн том худалдааны түнш, тиймээс Монгол, Хятадын худалдааг хэрхэн үр дүнтэй байлгах явдал Монголын бодолхийлэх чухал асуудал болох нь дамжиггүй. Тиймээс хамтын ажиллагааг хэрхэн харилцан ашигтай байлгах вэ гэдэг асуудал Хятад, Монгол хоёр улсын хөгжлийн нэгдмэл сонирхол болоод байна. Хоёр улсын удирдагчид хоёр талын хөгжлийн стратегия уялдуулж, харилцан ашигтай байлгах талаар

олонтаа цохон тэмдэглэдэг билээ.

Удаахид нь, агуулгаар бүрэн нийцэж буй. “Нэг бүс нэг зам” нь Ази, Европ, Африкийн эх газрыг дамнадаг, тэр дундаа Торгоны замын эдийн засгийн бүс нь Хятадаас Төв Ази ба Оросоор дамжин Европ тив (Балтийн тэнгис) хүрэх, Хятадаас Төв Ази, Баруун Европоор дамжин Персийн булан, Газар дундын тэнгис хүрэх, Хятадаас Зүүн өмнөд Ази, Өмнөд Ази, Энэтхэгийн далай хүрнэ. “Торгоны замын эдийн засгийн бүс ба XXI зууны далайн торгоны замын алсын хараа ба үйл ажиллагаа” хэмээх бодлогын баримт бичигт тусгаснаар “Нэг бүс нэг зам”-ын чиглэл чиглэлийн дагуу хуурай газраар олон улс дамжсан хонгил татаж, хонгилын дагуух том хотуудыг түшиглэсэн, худалдаа эдийн засгийн үйлдвэрийн паркуудыг хамтын ажиллагааны талбар болгосон эдийн засгийн зургаан коридорыг хамтдаа бүтээн байгуулах юм. Зургаан коридорт Хятад-Монгол-Орос, Шинэ Евразийн эх газрын гүүр, Хятад-Төв Ази-Баруун Ази, Хятад-Энэтхэг Хятадын хойг, Хятад-Пакистан, Хятад-Бангладеш-Энэтхэгийн коридорууд багтана. Хөгжил шинэчлэлийн хороо эдгээрээс “Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридор”-ыг тодорхой хоёр маршруттай байхаар тогтоосон: нэг нь Хөбэй мужаас Хөххотоор дайран Монгол, Орос хүрнэ, нөгөө нь Хятадын зүүн хойд бүсийн Далянь, Мүгдэн, Чанчунь, Харбинаас Манжуураар дайран Оросын Чита хүрнэ. Энэ хоёр маршрут харилцан нэгнээ нөхөж явах агаад Торгоны замын эдийн засгийн бүсэд шинээр нээн хөгжүүлэх эдийн засгийн бүс болж буй юм. Монголын газар зүйн байршил “Талын зам”-ыг нөхцөлдүүлж, гол хамтрагчаар Хятад, Орос оногдож буй. “Талын зам” төсөл хэрэгжиснээр Монгол Улс хурдны зам, төмөр зам, байгалийн хий, газрын тосны хоолойг хөгжүүлэх боломжтойгоос гадна Хятад, Оросын хооронд транзит тээвэр явуулах бололцоотой.<sup>3</sup> “Торгоны замын эдийн засгийн бүс”-ийн голчилж буй зүйл нь дэд бүтцийн бүтээн байгуулалт, тиймдээ ч Монголыг Хятад, Оростой холбосон 997 км хурдны зам, 1100 км цахилгаан дамжуулах шугам, Монголыг дамнасан төмөр зам, байгалийн хий болон газрын тосны хоолой гэсэн 5 төсөл бүхий “Талын зам”-тай угталцан нийцэж, хэлхээ холбоог бий болгоход яв цав нийцэж буй.

Гуравт, ашиг сонирхол давхцаж байгаа. “Нэг бүс нэг зам” нь холбогдох орнуудтай хөгжлийн стратегийн ашиг сонирхлоо

давхцуулж, тэдний дэвшүүлсэн хөгжлийн стратегитай боломжийн хирээр нэгтгэн цогцлоож, харилцан ашигтай болгохыг эрмэлздэг. Өдгөө Монгол, Хятадын хооронд Улаанбаатар-Бээжингийн төмөр зам байгаа хэдий ч уг олон улсын маршрут өнгөрсөн зууны 50-аад оны үед тавигдсан, зорчигч, бараа тээврийн хурдыг нь дээшлүүлэх шаардлагатай, ялангуяа цариг солих дарамттай тулгараад байгаа. Ази, Европыг холбох хамгийн дөт маршрутын хувиар Монгол Улс нэг талаар Хятад, Оросын худалдааны тээвэрт таатай, нөгөө талаар Евразийг дамнасан тээврийн коридор болох боломжтой. Иймээс “Нэг бүс нэг зам”, “Талын зам” хоёр стратеги холбогдсоноор Хятад, Монголын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны дэд бүтцийг сайжирч, хамтын ажиллагааны саад тотгорыг арилган, хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжтой. Энэ нь Хятад, Монгол хоёр улсын эрх ашигт тустай төдийгүй, Зүүн хойд Азийн орнуудын язгуур ашиг сонирхолд ч нийцэж буй билээ.

Ши Жиньпин дарга “Торгоны замын эдийн засгийн бүс”-ийг тайлбарлахдаа нээлттэй, ууч зарчмаар улс орнууд “таван зүйлийн хэлхээ холбоо”-г тогтоох тухай тодорхой санал дэвшүүлсэн билээ. “Таван зүйлийн хэлхээ холбоо” гэдэг нь бодлогоо уялдуулах, замаар холбогдох, худалдааг түргэвчлэх, валют урсгах, иргэд ойлголцох тус тус болно. “Таван зүйлийн хэлхээ холбоо” бол чухамдаа “Нэг бүс нэг зам”-ын бүтээн байгуулалтын алс хэтийн зорилт, “Нэг бүс нэг зам” бүтээн байгуулалтын чухал хэсэг, басхүү “Нэг бүс нэг зам”-ыг “Талын замтай холбох” гол зангилаа болой. Хятадын “Нэг бүс нэг зам”-ын холбогдох орнуудтай тогтоож буй хэлхээ холбоог анх удаа бүрэн хэмжээнд системтэйгээр үнэлсэн “Нэг бүс нэг зам”, “Таван зүйлийн хэлхээ холбоо” судалгааны тайлан”-д дурдсанаар холбогдох орнууд тус бүртэй хэрэгжүүлэх “таван зүйлийн хэлхээ холбоо” нь харилцан адилгүй байгаа, гэхдээ Төв Ази, Монгол Улс бодлогын уялдаа болон дэд бүтцийн хэлхээ холбоогоор тэргүүлж яваа, харин Хятад, Монголын худалдааг түргэвчлэх, валютын урсгал, иргэд хоорондын ойлголцол тал дээр илүү гүнзгийрүүлэх шаардлага бий.

Нэгдүгээрт, итгэлцэлд үндэслэсэн бодлогын уялдаа. Ши Жиньпиний дэвшүүлсэн нээлттэй, ууч зарчмаар “таван зүйлийн хэлхээ холбоо”-г бэхжүүлэх тодорхой саналд “бодлого хийгээд

хууль эрхзүйн хувьд бүс нутгийн эдийн засгийн интеграцид ногоон гэрэл асааж өгөх” бодлогын уялдааг тэргүүн зэрэгт тавих учиртай гэсэн агаад бусад дөрвөн зүйлийнхээ суурь, баталгаа болж өгөх ажээ. Хятад, Монгол хоёр талын харилцаа хэвийн болсноос хойш бодлогын уялдааны тал дээр үнэхээр үлгэж жишээ болохуйц ахицтай байгаа. 1994 онд Хятад, Монгол хоёр улс “Найрсаг харилцаа хамтын ажиллагааны гэрээ” байгуулснаар харилцаа бүх талаар хөгжих болов. 2003 онд Хятад, Монголын сайн хөршийн харилцан итгэсэн түншлэл тогтоож, харилцаа хөгжлийн шинэ шатанд гарав. 2011 оны 6 дугаар сард Хятад, Монгол хоёр улс харилцаагаа стратегийн түншлэл болгон ахиулснаар эрүүл саруул тогтвортой харилцах улс төр, хууль эрхзүйн суурийг тавьсан юм. 2014 оны 8 дугаар сар гэхэд Хятад, Монголын харилцаа иж бүрэн стратегийн түншлэл болгож дахин ахив. Өдгөө 30 орчим жилийн хугацаанд Хятад, Монголын улс төрийн итгэлцэл зузаарч, харилцан ашигтай хамтын ажиллагаа өргөжиж, одоо Хятад, Монголын харилцаа түүхийн хамгийн сайн үедээ явж байна. Ши Жиньпин дарга харилцан итгэсэн, харилцан ашигтай зарчмыг барьж, Хятад, Монголын харилцааг урт удаан, эрүүл тогтвортой хөгжүүлэх болно гэж тэмдэглэсэн нь бий. 2013 оны 7 дугаар сард Ли Көчян ерөнхий сайд Монгол Улсад албан ёсоор айлчилсан. Энэ үеэр хоёр тал худалдаа эдийн засаг, эрчим хүч, дэд бүтэц, санхүү, уур амьсгалын өөрчлөлт, хэвлэл мэдээлэл зэрэг салбар бүрийн хамтын ажиллагааны 15 гэрээнд гарын үсэг зурж, харилцааны агуулгыг баяжуулсан нь Хятад, Монголын бодлогын уялдаанд сайн суурийг тавьсан юм. Иймээс Хятад, Монгол, Орос гурван улсын тэргүүн нарын уулзалтын механизмын хүрээнд Хятад, Монгол хоёр талд илүүтэй чиглэсэн уулзалтын механизмыг бэхжүүлэх юм. Удирдлагын, яамдын, орон нутаг хоорондын гээд түвшин тус бүрд яриа хэлэлцээ хийх замаар холбогдох төслүүд дээр бодлогын зөвшилцөлд хүрэх учиртай. Хоёр улсын Засгийн газар хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагааны бүс, чөлөөт худалдааны бүсийн бүтээн байгуулалтын асуудлыг идэвхийлэн хэлэлцэх, Хятад, Монголын худалдаа эдийн засгийн үзэсгэлэн яармаг зэрэг хамтын ажиллагааны шинэ талбарыг бий болгох, хоёр талын эрчим хүч, зам тээвэр, санхүү зэрэг салбар бүрийн хэлхээ холбоог бий болгох төлөвлөгөөг талууд баталж гаргах хэрэгтэй.

Хэлхээ холбоог идэвхжүүлэх хүчин зүйлийг ашиглахын зэрэгцээ сааруулагч хүчин зүйлийг арилгаж, хамтын ажиллагааны олонлогийг бий болгон, ялгаатай талаа хүлээн зөвшөөрч адил талаа эрэлхийлэн, төслийн бүтээн байгуулалтад бодлогын талаас ногоон гэрэл асааж өгөх хэрэгтэй.<sup>4</sup>

Хоёрдугаарт, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг үсрэнгүй хөгжүүлж, зам харгуйгаар холбогдох. Зам харгуй дэд бүтцээр холбогдох нь худалдааг чөлөөтэй урсгах суурь болно. “Талын зам” стратегийн тодорхой дэвшүүлээд буй эн тэргүүний төлөвлөгөө бол хил дамнасан төмөр зам байгуулж, Хятад, Оросыг холбосон төмөр замын тээврийн хамтын ажиллагааг идэвхтэй өрнүүлэн, одоо байгаа тээврийн чадавхийг нэмэгдүүлэх явдал юм. Хятад, Монгол хоёр хил дамнасан дэд бүтэц, ялангуяа зам харилцааны систем байгуулах явдлыг стартегийн хөгжлийн үсрэнгүй ахиц дэвшил гаргах үндэс гэж үзэж буй тул төмөр замын бүтээн байгуулалтыг түргэвчилэхээр хоёр тал төмөр замын дөрвөн гарц нэмж барих талаар санал нэгдсэн билээ. “Талын зам” болон “Торгоны зам” төслийг угталцуулах тал дээр хоёр талын хамтын ажиллагаанд хөгжүүлэхээр заасны дагуу зам тээвэр, харилцаа холбоо, хил гаалийн салбарын үндэс суурийг тавих хэрэгтэй.<sup>5</sup> Өдгөө Хятад, Монголын анхны стандарт цариг бүхий төмөр зам Сэхэ боомт дээр хил дамнасан төмөр замын төсөл болоод буй нь хоёр улсын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд нэн тустай юм. Мэдээж орчин үеийн торгоны зам уламжлалт худалдаагаар хязгаарлагдахгүй, төмөр зам, авто зам, агаарын тээвэр, газрын тос, хийн хоолой, шилэн кабель, мэдээлэл харилцаа зэрэг цогц хамтын ажиллагаа бүхий уудам орон зай, олон өнцгийг хамарсан хэлхээ холбоо байх бөгөөд зам харилцааны зэрэгцээ холбогдох тогтолцоог зүйл заалтаар боловсруулан гаргах нь бас нэг чухал тал буюу хатуу ба зөөлөн дэд бүтцийг бүхэлд нь угталцуулан уялдуулах учиртай.<sup>6</sup> Хятад, Монгол зам харгуйн хэлхээ холбоог бий болгоход хатуу дэд бүтцийг бэхжүүлэх шаардлагатай, худалдааг хөнгөвчлөх зэрэг зөөлөн орчныг бий болгох бүүр ч их шаардлагатай.

Гуравдугаарт, харилцан нөхөх шинждээ тулгуурлан худалдааг өсгөх. Худалдааг саадгүй явуулах гол зүйл нь худалдаа, хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх явдал билээ. Хятад, Монгол хоёр улс удаан

хугацааны турш худалдаа эдийн засгийн нягт харилцаатай явж ирлээ. Өнгөрсөн 20 жилд Хятад, Монголын худалдаа 50 дахин нэмэгдсэн, Хятад улс 10 гаруй жил тасралтгүй Монголын хамгийн том худалдааны түнш, хөрөнгө оруулагч орон болсон, 2015 онд Хятадаас Монголтой хийсэн худалдаа Монгол Улсын нийт гадаад худалдааны 62 хувийг эзэлж байв. Монголын экспортын бүтээгдэхүүний 90 хувь нь Хятад руу гарч, импортынхоо 30 эргэм хувийг Хятадаас авчээ. Монголоос Хятад руу гарч буй бүтээгдэхүүн дийлэнх нь уул уурхай, малын гаралтай түүхий эд болон зарим боловсруулсан бүтээгдэхүүн, мод модон эдлэл, металлургийн гэх мэт бүтээгдэхүүн байна. Харин Хятадаас гол төлөв хүнс, архи тамхи, химийн болон аж үйлдвэрийн бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж импортлодог. Хятадын “Нэг бүс нэг зам”, Монголын “Талын зам” нь ухагдахуун, агуулгаараа бүрэн нийцэж, маш үр дүнтэйгээр уялдан зохицож байсан нь Хятад, Монгол, Оросын эдийн засгийн коридорыг бүтээн байгуулах тухай санал нэгдэхэд том дэвсгэр болж өгсөн ба Хятад, Монголын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаа өргөн ирээдүйтэй, асар их нөөц бололцоотой байгаа юм. Иймээс Хятад, Монгол хоёр тал боломж завшааныг атган авч, худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны харилцан нөхөх давуу талаа ашиглан худалдаа хөрөнгө оруулалтын уламжлалт хамтын ажиллагаагаа урагшлуулсны үндсэн дээр үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг идэвхтэй ахиулах, том төслүүдийн хамтын ажиллагааг бодитой зүтгүүлэх, ХАА тариалан, ХАА-ын парк байгуулах төслийн хамтын ажиллагааг өрнүүлэх, аялал жуулчлал, эмнэлэгийн зэрэг үйлчилгээний салбарыг эрчтэй ахиулах зэргээр хоёр тал бодитоор хамтран ажиллах шинэ салбаруудыг нээн хөгжүүлэх хэрэгтэй. Талууд цаашид ч Хятад, Монголын Засгийн газар хоорондын худалдаа эдийн засгийн хамтарсан комисс, Хятад, Монголын уул уурхай, хэлхээ холбоо хамтын ажиллагааны зөвлөл зэргийг сайтар ашиглаж, эдгээр хамтын ажиллагааны механизмуудад ажил үүргээ хуваарилан, хамтран ажиллах шаардлагатай. Хятад, Монгол хоёр тал “Эрээн-Замын Үүдийн хил дамнасан эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн нэгдсэн төсөл”-ийг даруйхан ажил хэрэг болгож, тус бүсийн бүтээн байгуулалтыг урагшлуулж, 2004 оны “Хятад Монголын хилийн боомт, түүний удирдлагын тогтолцооны хэлэлцээр”, 1995 оны “Хятад, Монголын хилийн төмөр замын

хэлэлцээр”-ийг шинэчлэн өөрчилж, худалдаа, хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх хэрэгтэй байна.

Дөрөвдүгээрт, санхүүгийн хамтын ажиллагаанд тулгуурласан валютын урсгалыг нэмэгдүүлэх. Хоёр улсын худалдаа эдийн засгийн харилцаа зузаарч, иргэд хоорондын харилцаа нэмэгдэхийн хирээр хоёр талын мөнгөн тэмдэгт солилцох цар хүрээ тасралтгүй өргөжсөөр байна. 2014 онд “Хятадын Ардын банк, Монгол банкны своп хэлцлийн гэрээ” байгуулж, Хятад, Монгол хоёр улсын Төв банк хоорондын харилцаа хамтын ажиллагаа шинэ шатанд гарсан билээ. Хятад, Монголын мөнгөн тэмдэгтийн харилцан солилцоо өргөжиж, өөрсдийн мөнгөн тэмдэгтээр худалдааны тооцоог явуулахыг дэмжих нь хоёр талын худалдааны эргэлтийг түргэтгэх, хөнгөвчлөх баталгаа болно. Басхүү хоёр улсын санхүүгийн зах зээлийг тогтвортой байлгах, худалдаа, хөрөнгө оруулалтын хөгжлийг урагшлуулахад тустай. Урьд нь монгол төгрөг чөлөөтэй хөрөвдөггүй валютын төрөлд хамаардаг байсан, хоёр талын мөнгөн тэмдэгт харилцан солилцох своп хэлцэл байгуулснаас хойш Монгол Улс их хэмжээний юань хэрэглэж, худалдаа хөрөнгө оруулалтын салбартаа зарцуулсан бол Хятад улс монгол төгрөгийг огт хэрэглэж байгаагүй юм. 2016 олы 8 дугаар сард Хятад, Монголын Төв банк хооронд своп хэлцэл байгуулснаар монгол төгрөгийг анх удаа гаргаж, монголын мөнгөн тэмдэгтийг солих үйлчилгээ хятадын нутаг дотор байгуулагдах болсон нь хоёр улсын худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааг урагшлуулах, хоёр талын мөнгө тэмдэгтийн эрэлт нийлүүлэлтийг тэнцвэржүүлэх, ханшийг тогтвортой байлгах, дотоодын ААН-үүдэд “гадагш гарах”, мөнгөн тэмдэгтийн урсгал, тооцоог сайжруулахад чухал ач холбогдолтой болов. Хятад, Монголын санхүүгийн хамтын ажиллагаа “Нэг бүс нэг зам”, “Талын зам”-тай нягт уялдаж, шаардлагатай санхүүгийн үйлчилгээ, дэмжлэгийг үзүүлэх юм. Хятад, Монгол хоёр улсын Засгийн газар албан ёсны капитал, гадаад валютын нөөцийн стратеги чадавхийг сайтар дайчилж, олон талт Засгийн газрын санг цаашид ч ашиглан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкнаас санхүүгийн дэмжлэгийг авах хэрэгтэй. Үүний зэрэгцээ хоёр улсын санхүүгийн байгууллагууд хамтарсан зээл авах, дэд бүтцийн бонд гаргах зэрэг арга хэлбэрээр дэд бүтцийн санхүүжилтийг ашиглах хэрэгтэй. Нэгэнт байгаа санхүүгийн байгууллага болох Азийн дэд

бүтцийн хөрөнгө оруулалтын банк, БРИКС-ийн банк, Торгоны зам сан зэрэг нь Хятад, Монгол хоёр улс “Нэг бүс нэг зам”, “Талын зам”-ыг холбохдоо идэвхтэй үр ашигтайгаар хөрөнгө санхүү босгох боломж олгож, Хятад, Монголын хамтын ажиллагаанд үр дүнтэй хөшүүрэг болох юм.

Тавдугаарт, иргэд хоорондын соёлын харилцаанд тулгуурласан иргэдийн ойлголцол. “Улс хоорондын харилцаа иргэдийн дотносноос ургана, иргэдийн дотносол сэтгэлийн ойлголцлоос ургана”. Иргэдийн ойлголцол гэдэг нь “Нэг бүс нэг зам”-ын бүтээн байгуулалтын нийгмийн үндэс суурь бөгөөд боловсрол, аялал жуулчлал, эмнэлэг, шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагаа, ардын дипломат зэрэг нь түүний гол ухагдахуун, ондоо соёл иргэншил, шашин шүтлэгийн харилцаа хэлэлцээг урагшлуулах нь түүний зорилт юм. Хятад, Монгол хоёр улсын болвсрол, соёл, шинжлэх ухааны харилцааны тухайд хамтын ажиллагааны сайн суурьтай. Өнгөрсөн зууны 80-аад онд Хятад, Монголын харилцаа хэвийн болсноос хойш иргэд хоорондын харилцаа цэцэглэж, ялангуяа боловсролын салбарын хамтын ажиллагааны цар хүрээ тасралтгүй өргөжив. 1994 онд хоёр улс “Хятад, Монголын соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр” байгуулснаас хойш соёлын солилцоо өдрөөс өдөрт дэвжив. 2011 онд “БНХАУ-ын Боловсролын яам, Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам хоорондын 2011-2016 оны боловсролын солилцоо, хамтын ажиллагааны төлөвлөгөө”-нд гарын үсэг зурснаар Хятад, Монголын боловсрол, соёлын хүрээнийхний харилцаа солилцоо улам бүр механизм болон бүрэлдэж, хоёр улсын хэл бичгийн харилцаа улам гүнзгийрч байна. 2012 онд Хятад Монгол хоёр улс “Соёлын сар”-ын арга хэмжээг амжилттай зохион байгуулсан. 2014 оныг Хятад, Монголын найрсаг солилцооны жил болгон зарлаж, “Хятад, Монголын найрсаг солилцооны жилийг тэмдэглэх хөтөлбөр”-т хүмүүнлэгийн салбарын 22 арга хэмжээг тусгасан нь хоёр улсын стратегийн хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлэхэд тустай болсон ба стратегийн угталцалд чухал ухагдахуун болох нь дамжиггүй. Хятад, Монголын хүмүүнлэгийн харилцаа бол иргэд хоорондын оюун сэтгэлийн харилцааны чухал суваг агаад хоёр талын хамтын үнэт зүйл, гоо зүйн үнэлэмж, эдийн засгийн хамтын ажиллагааны гарааны цэг гэж хэлж болох төдийгүй

зөрчлийг бууруулагч, мөргөлдөөнийг саармагжуулагч болж чадах билээ. Гагцхүү олон суваг бүхий байснаар үл ойлголцлыг арилгах боломжтой. Ойлголцлыг нэмэгдүүлэхийн тулд хамтын хичээл зүтгэл чухал, нийгмийн болон иргэдийн харилцааны сувгийг өргөжүүлж, харилцаа хамтын ажиллагаанд таатай сайхан соёлын уур амьсгал бүрдүүлэх, иргэд ард түмний нягт харилцаа, найрсаг солилцоонд сайн дэмжлэг хэрэгтэй. Хоёр улсын гол мэдээллийн хэрэгслүүд харилцаагаа сайжруулж, мэдээлэл сурталчилгаагаа өргөжүүлэх ёстой, энэ нь Хятад, Монголын найрамдал, сайн хөршийн найрсаг харилцааг зузаатгахад тустай. Үүнээс гадна эрдэм шинжилгээний байгууллагууд хооронд хамтын ажиллагааны механизм байгуулж, биет бус соёлын өв, ардын уламжлалт соёлын харилцаа хамтын ажиллагааг ахиулах, тус тусын үндэстний онцлог, түүхэн уламжлалыг үзүүлэн таниулж, өдрөөс өдөрт нягтшиж буй улс төр, эдийн засаг, худалдааны харилцаанд хүмүүнлэг, оюунлаг баялгийг нийлүүлж, хамтын ажиллагааг өнө удаан хөгжүүлэх баталгааг бий болгох юм.

Хэдийгээр Хятад, Монголын харилцаа, хамтын ажиллагаанд худалдааны бүтэц хэт өрөөсгөл, хятадаас худалдааны хамаарал ихтэй, соёлын тусгаарлал зэрэг сорилт байгаа боловч Хятадын “Нэг бүс нэг зам”, Монголын “Талын зам”-ын ойлголт, агуулга, ашиг сонирхол асар сайн давхцаж, хамтын ажиллагааны боломж нь сорилтоосоо хавьгүй илүү байгаа. Бодлогын уялдаа, зам харилцаа, худалдааны харилцаа, валютын солилцоо, иргэдийн ойлголцол гээд агуулга тус бүрээр авч үзвэл “Нэг бүс нэг зам”, “Талын зам”-ыг холбох боломжтой байна гэдэг нь “Таван зүйлийн хэлхээ холбоо” ч боломжтой байгаагийн илрэл, улам улмаар үүнээс хамтдаа бүгд хожих болно.

#### Ашигласан материал:

<sup>1</sup> Хуа Чин: “Нэг бүс нэг зам” ба Монгол Улсын “Талын зам”-ын стратегийн уялдааг судлах нь, “Гуожи Жаньван” сэтгүүл, 2015.06.

<sup>2</sup> Ж.Баясах: Монгол Улс, БНХАУ-ын харилцаа: Стратегийн түншлэлээс Иж бүрэн стратегийн түншлэл рүү. “Монголын мэдээ” сонин, 2015 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн дугаар.

<sup>3</sup> Н.Төмөр: Монгол, Хятадын эдийн засгийн хамтын ажиллагаа ба Монгол, Хятад, Оросын эдийн засгийн коридорын бүтээн байгуулалт, “Хармөрөн мужийн Зүүн хойд Ази судлалын хурлын 2 дахь удаагийн төлөөлөгчдийн их хурлын эмхтгэл”, 2016.03.

<sup>4</sup> Вань Чөнцай: “Нэг бүс, нэг зам”-ын агуулга баяжиж, ач холбогдол өсөв. Синьхуа агентлаг, 2015 оны 03 дугаар сарын 29-ний өдөр.

<sup>5</sup> Н.Алтанцэцэг: Монгол Улсын “Нэг бүс, нэг зам” стратеги дэх боломж ба сорилт, “Нэг бүс, нэг зам”-ын бүтээн байгуулалт ба Лунжяны цогц хөгжлийн дээд хэмжээний форумын эмхтгэл”, 2016.06.15

<sup>6</sup> Дин Шяошинь: Торгоны замын эдийн засгийн бүсийн стратегийн шинж хийгээд хэрэгжих боломжийн талаарх дүн шинжилгээ, 2014.03.